



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№191 /401/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.10.25

Цаг үе, үйл явдал

## САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



ЗХЖШ-ын дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн анхдугаар хуралдааныг Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, ЗХЖШ-ын дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн дарга бригадын генерал С.Ганбямба удирдан энэ сарын 25-ны өдөр зохион байгуулав.

Энэхүү хуралдаанд Зэвсэгт хүчний Жанжин штабын Хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн дэд хурандаа Н.Гантулга, Материал техникийн газрын ахлах мэргэжилтэн дэд хурандаа Х.Санчирдорж, Захиргааны удирдлагын хэлтсийн захиргааны удирдлагын ахлах мэргэжилтэн хошууч О.Нямцогт, Санхүүгийн хэлтсийн төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн ахлах мэргэжилтэн хурандаа П.Эрдэнэбаяр,

Сургалт, бэлтгэлийн газрын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн төлөвлөлтийн мэргэжилтэн хошууч Э.Батжаргал, Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалуудын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга хурандаа С.Жаргалсайхан, Г.Чулуунзагд, Л.Мөнхбат, О.Нацагдорж, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Балжинням нарын гишүүд оролцов.

Хуралдааны эхэнд ЗХЖШ-ын Жендерийн асуудал хариуцсан ажилтан бөгөөд Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн олон улсын гэрээ, эрх зүйн мэргэжилтэн ахмад Б.Золжаргал "Зэвсэгт хүчинд Жендерийн эрх тэгш байдлын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ,

өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал"-ын талаар танилцуулга хийсэн юм. Үргэлжлүүлэн Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалуудын болон Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга нар командлал, удирдах газарт Жендерийн эрх тэгш байдлын чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулга хийв.

Хуралдааны төгсгөлд Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба ЗХЖШ-ын дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөлийн орлогч дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдэд хандаж үүрэг чиглэл өгсөн юм.

Тэр бээр "Батлан хамгаалах салбар нь үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан нэг хүйс давамгайлдаг хэдий ч Жендерийн тэгш байдлын зарчмаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүд зэрэг олон бүлгийн хүмүүсийн оролцоог ханган тэдний саналыг авдаг, зөвшилцдөг үр дүн бүхий тогтолцоог хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна.

Үүний нэг жишээ нь Зэвсэгт хүчний хүний нөөцийн

төлөвлөлт, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд зөвлөх чиг үүрэг бүхий ЗХЖШ-ын дэргэдэх Жендерийн орон тооны бус салбар зөвлөл байгуулан ажиллаж байгаа явдал юм. Тус салбар зөвлөл нь ЗХЖШ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/601 дүгээр тушаалаар шинэчлэгдэн байгуулагдсан юм. Өнөөгийн хуралдаанаар ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, удирдах газрын Жендерийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй асуудлыг хөндсөн нь чухал арга хэмжээ боллоо гэж дүгнэж байна.

Цаашид салбар зөвлөлийн хурлыг тогтмолжуулан улирал тутамд зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийг ажил хэрэг болгох талаар салбар зөвлөлийн гишүүд санаачилгатай, хариуцлагатай ажиллах шаардлагатай онцолсон юм.

Мөн жендерийн сургалт, сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах, Зэвсэгт хүчний удирдлагын бүрэлдэхүүний жендерийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамруулах, сургалт зохион байгуулах хэрэгтэй" гэдгийг онцоллоо.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 1	☁️ -13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	☁️ 23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,410	3,420
EUR 🇪🇺	3,380	3,405
CNY 🇨🇳	466	471
RUB 🇷🇺	52.50	52.80
JPY 🇯🇵	23.10	23.50
KRW 🇰🇷	2.40	2.45

### ЗУРХАЙ



2022.10.25 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 30

**НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ГАХАЙ ӨДӨР**

**Үс засуулбал:**  
Эрлэг лугаа учирна  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
07.26-17.47  
Барилдлага:  
Хүчин төгсөх  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Төрөн түгэхүй

## САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Умард Атлантын гэрээний байгууллага (NATO)-оос Батлан хамгаалах боловсролыг хөгжүүлэх "Deer Mongolia" хөтөлбөрийн хүрээнд Цэргийн манлайллын талаарх Монгол Улсын Зэвсэгт хүчний хэтийн төлөв, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодотгох зорилготой сургалтыг энэ сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Сургалтын хүрээнд өчигдөр ЗХЖШ-ын СБГ-ын дарга бригадын генерал Г.Болор, Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд, БСТГ-ын дарга, Цэргийн хэлтсийн дарга хурандаа Ш.Амарбаясгалан, АУГ-ын ЭДА-ны хэлтсийн дарга дэд хурандаа Б.Энхцэг нар НАТО-гийн сургагч багш нарыг ЗХЖШ-т хүлээн авч уулзсан юм.

ЗХЖШ-ын СБГ-ын газрын дарга Г.Болор уулзалтын үеэр хэлсэн үгэндээ, "Тус хөтөлбөрөөр бид олон улсын цэргийн сургалт бэлтгэл, манлайлагч алба хаагчдыг хэрхэн бэлтгэдэг талаар туршлага судлахын зэрэгцээ үүнийг Монгол Улсын Зэвсэгт хүчин цаашдын хөгжлийн бодлогодоо хэрхэн нутагшуулах талаар санал зөвлөмжийг солилцож ажиллана. Энэ удаагийн сургалтад голчлон ЗХЖШ-ын ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдийг хамруулахаар төлөвлөсөн" хэмээлээ.



## "АЛДАР"-ЫНХАН ӨНГӨТЭЙ БАЙНА

Буудлагын спортын дэлхийн аварга шалгаруулах (ISSF World shooting championships) 53 дахь удаагийн тэмцээн Египетийн Каир хотноо зохион байгуулагдаж байгаа бөгөөд 88 орны 1088 тамирчин цэц мэргэнээ сорин өрсөлдөж байна.

Энэ удаагийн тэмцээнд олимпын дасгал тус бүрд эхний дөрвөн байрт шалгарсан тамирчдад

"Парис-2024" олимпын эрхийг олгох юм.

Эл тэмцээнд Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооноос МУГД, дэд хурандаа Л.Ундралбат дасгалжуулагчтай баг тамирчид оролцож байгаагаас ОУХМ, ахлагч Э.Даваахүү, Ц.Мөнхзул нар 50 м-ийн гар бууны холимог багийн төрөлд мөнгөн медаль хүртлээ.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 633,247,821

Эдгэрсэн

Нийт: 612,270,728

Нас барсан

Нийт: 6,584,151

## ЭХ ОРОН ТАНЬ ТАЙВАН АМГАЛАН ХОНОЛОО ГЭХ ШИГ...



км-ээр хиллэдэг нүд чилээм өргөн уудам нутаг дэвсгэртэй аж. Цагийн бүсийн хувьд Улаанбаатар НЗНЦ+8. Энэ нутаг Хатанбулагийг бодвол техникийн хөлөөс холхон нам гүмхэн юм. Байгаль, цаг уурын онцлогоос болоод ч тэр үү суманд хашаатай өрх нэн ховор харагдана. Соёл, олон нийтийн үйлчилгээний томоохон цогцолборуудаас нь харвал эл нутаг хүүхэд, залуучуудаа чиглэн хөгжиж буй нь илхэн харагдах аж. Хараа бэлчээх өргөн уудам нутаг дэвсгэртэй тул айл өрхүүд нь сийрэгхэн суурьшжээ. Өнөөгийн Улаанбаатарын давчуухан иргэн энд ирвээс өндөрхөн дэнжээс тоолоод дөнгөхмөөр санагдах нь лавтай биз.

**Бидний томилолт үргэлжилсээр...**

Сумын төвөөс 1,5км давхиад тохижилт үзэмж сайтай 40 жилийн ойгоо угтах

гэж буйг илтгэх дурсгалын хөшөө бүхий цэргийн ангийн цэмцгэр хашаа биднийг угтлаа. Тусгай ротууд нь орон нутагтаа үндсэн үүрэг гүйцэтгэхээс гадна байгууллагын соёл, эмх цэгц, зохион байгуулалттай үйл ажиллагааг харуулж Зөвсэгт хүчнээ сурталчлах ажлыг тогтмол хийдэг нь харагдаж байв. Ангийн шалганаар нэвтрэх мөчид хамгийн түрүүн нүдэнд туссан зүйл бол галын булан байлаа. Галын буланг харвал яаралтай үед хэрэглэх тоног төхөөрөмж хэрэгсэл нь стандартын өндөр түвшинд хангагдсан учир ямар ч тохиолдолд эрсдэлийн ард хохиролгүй гарах бүрэн дүүрэн итгэлийг төрүүлэв.

Энэ мэт орчны сонин содонг ажин явахад нэг өдөр хормын зуур өнгөрч орчлонд харуй бүрий ноёлжээ. Говьд ирсэн хүн бүр өглөөний наранг харах гэж зүтгэдгийн

учрыг тайлах бодолтой эртхэн бослоо. Бөртгийг харагдах жижиг толгод ч энд үгүй учир наран газраас ургаж буй мэт харагдах нь үзэсгэлэнтэй агаад амар тайвныг мэдрүүлж байв. Мөн Ротын жагсаалын талбайгаас дэрхийн нисэлдэх энх тайвны бэлгэдэл тагтаан сүрэг эх орон тань тайван амгалан хонолоо гэх шиг...

Ангийн өдөр тутмын үйл ажиллагаа эхэлсэн бололтой гэнэт л цугларах дохио хангинах нь тэр. Энэ үеэр дутуу товчилсон дүрэмтэй, малгайгаа гартаа атгасан ЦАХ-д ротын хашааны гадна байрлах албан тушаалын орон сууцнаас гүйлдэж, зарим нь сумын төвөөс хөнгөн чанарын мотоциклоор давхин ирж яаран зогсоцгооно. Эндээс л цэрэг хүний амьдралын үүрэг хариуцлага болоод тушаалаар ажилладаг эх орноосоо эс урвах хөвүүдийг

харж байв.

Эл ангийн хамт олон төсөв хөрөнгөгүй гэж хойш суусангүй. Биеийн тамирын дасгалын тернижор, спортын болон урлагийн заал гээд байхгүй юм энд нэг үгүй. Эдгээрээс гойд сайрхам санагдсан нь дээр дурдсан галын булан, мөн зэвсгийн өрөөний зэвсгийн тавиур. Зургийг нь камертаа буулгахдаа бүх л цэргийн ангиудад үзүүлэх сэн хэмээн бодон явсан юм. Энэ хүрээд бидний тус ангид ажиллах үүрэгт ажил дуусч ангийн захирагчийн баталсан удирдамжийн дагуу шалган туслах ажлын дүнгээ нэгтгэн танилцуулаад дараагийн салбарлуугаа яаран хөдөллөө.

Монгол Улсын агаарын хил тайван байна.

**Ахмад Л.САРАНЗАЯА**  
2022.10.02

**Зэвсэгт хүчний 253 дугаар салбар**

Монгол Улсын Зөвсэгт хүчний агаарын цэргийн 253 дугаар тусгай рот билээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт оршдог ба энэ сум нь 1137092 га нутаг дэвсгэртэй, нутаг

хамт олон бол Зэвсэгт хүчний агаарын цэргийн 253 дугаар тусгай рот билээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутаг дэвсгэрт оршдог ба энэ сум нь 1137092 га нутаг дэвсгэртэй, нутаг

дэвсгэрийн хэмжээгээр аймалтаа хоёрдугаарт ордог. Баруун, баруун хойд хэсгээрээ Хөвсгөл, Мандах, Сайхандулаан, зүүн, зүүн хойд, зүүн өмнөд хэсгээрээ Эрдэнэ, Өргөн, Сайншанд, урд талаараа БНХАУ-тай 60

## НҮБ-ЫН ШТАБЫН ОФИЦЕР /UNSOC/- ЫН ДАМЖАА ХИЧЭЭЛЛЭЖ БАЙНА



оронд үүрэг гүйцэтгэх аж.

Энэ удаагийн дамжаа Монгол Улсын Зөвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж эхэлсний 20 жилийн ойн үеэр хичээллэж буйн зэрэгцээ АНУ-ын Энхийг дэмжих санаачилгын хөтөлбөр "GPOI"-ийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Зөвсэгт хүчин бие даан явуулж байгаагаараа онцлог юм.

Дамжааг Монгол Улсын Зөвсэгт хүчнээс 12, "Дэлхийн энхийг санаачлах хөтөлбөр"-өөс нэг чиглүүлэгч багш удирдан хичээллүүлж байгаа бөгөөд Монгол, Балба, Вьетнам, Тайланд, Филиппин, Шри-Ланк зэрэг орны 31 офицер, ахлагч дамжаанд хамрагдаж байна.

НҮБ-ын "Цэргийн ажиглагч офицер"-ын дамжаа Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвд 10 дугаар сарын 17-ны өдөр эхэлсэн бөгөөд ирэх сарын 4-ний өдөр дуусах юм.

Дамжаа нь стратеги оперативийн түвшинд онолын мэдлэг олгож дадлагаар баталгаажуулан 2 үе шаттай явагдах ба сүүлийн шатанд нийт бие бүрхэлдэхүүн бүлгийн Команд штабын сургууль хийж хийсвэр ажиллагааны газар

## АНГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ВОЛЕЙБОЛЫН ТЭМЦЭЭНД...



**Зэвсэгт хүчний 065 дугаар анги**

Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу сургуулийн жилийн нээлтийн арга хэмжээний үеэр "Мэргэжил бүхэн сайхан" сэдвийн хүрээнд гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд 10 баг оролцож, ур чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт хошууч Ц.Ариунболд ахлагчтай ар талын хамт олон, дэд байрт ахмад Н.Ренчинбямба ахлагчтай холбооны ротын 1 дүгээр баг, гутгаар байрт хошууч Г.Ууганбаатар ахлагчтай радиолокаторын ротын 1 дүгээр баг тус тус шалгарлаа.

Мөн тэмцээний үеэр шилдэг довтлогч, шилдэг холбогч, тэгш тоглогч номинац шалгаруулсан ба шилдэг довтлогчоор ахмад Н.Ренчинбямба (холбооны ротын захирагч), шилдэг холбогчоор энгийн Д.Цэцэгбадам (үйлчлэгч), тэгш тоглогчоор ахлах ахлагч Б.Отгонбаяр (ээлжин дарга, техникч) нар тодорсон юм.

**Ахмад Л.САРАНЗАЯА**

## ШИНЭ ЦЭРГҮҮД СЭТГЭГДЭЛ ӨНДӨР БАЙНА



**Зэвсэгт хүчний 186 дугаар анги**

2022 оны II ээлжээр цэргийн жинхэнэ албанд татагдсан хугацаат цэргийн алба хаагчдад "Дайчин алдрын танхим"-ын үйл ажиллагаа, ангийн түүхэн танилцуулгыг хийж, Зэвсэгт хүчний зорилго, ангийн үйл ажиллагааг сурталчиллаа.

Энэ үеэр хугацаат цэргийн алба хаагчид сэтгэгдлээ хуваалцаж, баярласан талархсан илэрхийлж, олон сонирхолтой болоод мэдвэл зохих мэдээллийг олж авснаа илэрхийлж байсан юм. Мөн тус анги нь Батлан

хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний зорилго, анги байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалт бэлтгэл, өдөр үйл тутмын ажиллагааг хэрхэн явагдаж буй байдал, тэдний алба хаах орчин, нөхцөлийг танилцуулах зорилгоор 2022 онд цэргийн жинхэнэ албанд татагдсан хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрийн төлөөлөлд "ӨДӨР БҮР НЭЭЛТТЭЙ" сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж байна.

**Хошууч О.ОТГОНЦЭЦЭГ**

## ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний нэгдүгээр байрт "Артиллерийн цэрэг Тийрэлтэт артиллерийн үүсэн байгуулагдсаны дивизионы батарейны 100, 101 жил, ангийн 55 захирагч, ахмад жилийн ойг угтан зохион Б.Батбуян, хоёрдугаар байгуулж буй "Цол бүхэн байрт Хуягт, техникийн сайхан" урлаг спортын засварчин, цогцолбор тэмцээн 2022 ахлагч Ч. Сумъяабазар, оны 10 дугаар сарын гуравдугаар байрт 20-ны өдөр "Шатрын захирагчийн орлогч, тэмцээн"-ээр амжилттай захиргааны удирдлагын эхэллээ. тасгийн дарга, дэд хурандаа Г.Баярхүү нар тус тус байр эзэллээ.



## СУРГАЛТ

### МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №09

#### ЭВЭР

Эвэр бол титэмт Ла үсгийн гол бүрдүүлэгч, ялгагч зурлага юм. Бичмэл тигээр, эврийг дөрвөлжиндүү мохоо өнцөг гаргаж дээш эргүүлэн, үзүүрийг нарийхан, уран гаргаж бичвэл сайн. Үхэр зэрэг мал, амьтны эврийн үзүүр нарийн байдаг лугаа адилхан гэж мэдэгтүн.

Эврийг үгийн эхэнд титэмд нь, дунд, адагт шүдэнд нь зайгүй нийлүүлж, залгаж бичдэг. Хөндий бичиж хэрхэвч болохгүй.

Дармалаар:

Бичмэлээр

